



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 670
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН МОГОД
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Могод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Д.Ганцэцэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021339

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Д.Ганцэцэг Могод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Д.Ганцэцэгийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Д.Ганцэцэгт

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН МОГОД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАВААДОРЖИЙН ГАНЦЭЦЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.07.23

ИРГЭДИЙН ИРЭЭДҮЙ БИДНИЙ ГАРТ

1. Монгол Улсын Засгийн газар, аймаг сумын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрийг дэмжиж хамтарч ажиллана.
2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр иргэдийг жижиг дунд үйлдвэр байгуулахад анхаарч хамтарч ажиллана
3. Малын үйлдвэр угсааг сайжруулах үр ашгийг нь дээшлүүлэхэд анхаарч малын тоо бус чанарт тулгуурлан уламжлал-шинэчлэлийг хослуулан хөгжүүлэхэд анхаараал хандуулж ажиллана
4. Малчид, ард иргэдийг малын тэжээлийн ургамал тариалах тал дээр идэвх санаачлагатай хамтарч ажиллана.
5. Эрүүл амьдарлын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд идэвх санаачлагатай хамтарч ажиллана
6. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэхэд идэвхтэй ажиллана.
7. Орон нутгийн туулахад бэрхшээлтэй зам давааг ердийн аргаар ОНХС-ийн хөрөнгөөр засаж сайжруулахад идэвх санаачлага гаргаж хамтарч ажиллана
8. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлэх үлдээх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана
9. Нийтийн биеийн тамир спортын орчин нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтарч ажиллана
10. Залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж урлаг спортын наадмыг жил бүр зохион байгуулж хэвшүүлэхэд анхаарч хамтарч ажиллана.

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

Булган аймгийн Могод сумын

Баясгалант багийн иргэн Д. Ганцэцэг

ГЕ87110105

97029995, 86562909

ganaa87110105@gmail.com